



*Батлан хамгаалах их
сургуулийн Удирлагын
академийн магистрант,
хошууч Б.Наранбаяр*

ОРГОСОН ЭТГЭЭДИЙГ ЭРЭН СУРВАЛЖЛАХ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛЛАГАА

Хорих ял эдлэж байгаад оргосон ялтан нийгэмд үзүүлэх хор уршиг ихээр гаргах бөгөөд ялтан оргосон талаарх мэдээ, мэдээллийг сонсмогц нийгмийн гишүүд тодорхой хэмжээгээр айдаст автдаг. Иймд оргодлыг эрэн сурвалжлах ажиллагааг нэн даруй гүйцэтгэвэл зохино. Энэ удаагийн илтгэлд оргох гэмт хэрэг үйлдэж буй ялтнуудыг эрэн сурвалжлах ажиллагааг боловсронгуй болгох талаар өөрийн туршлагад тулгуурлан судалгаа болон төсөөлөлийн хүрээнд авч үзэн тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлэхийг зорилоо.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь эрүүгийн хэргийн талаархи шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх явцдаа эрүүгийн ялын зорилтыг хангах үүднээс гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгэгдсэн ялтныг нийгмээс тусгаарлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан сэжигтэн, яллагдагчийг хорих, хоригдогч, ялтны зүгээс үйлдэж болзошгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг. Хорих байгууллагын үндсэн чиг үүргийн нэг болох ялын зорилгыг хангах, ялтан хоригдогчдын зүгээс гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, тэдний дунд дэг журмыг сахиулахад оршино. Өнөөгийн

практикт ял эдлүүлэх ажиллагааны явцад ялтны зүгээс үйлдэж буй гэмт хэргийн дундаас оргох гэмт хэрэг багагүй гарсаар байна.

Одоо мөрдөгдөж байгаа Эрүүгийн хуулийн тайлбар толь¹⁸ Монгол Улсын эрүүгийн хуулийн 262 дугаар зүйлд тухайн гэмт хэргийг тодорхойлсон бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол улсын хуулийн 113 дугаар зүйлд Оргосон ялтныг эрэн сурвалжлах асуудлыг тусгасан. Нөгөөтэйгүүр “Хорих ангийн харуул хамгаалалтын болон хяналт тавих журам”¹⁹-ын холбогдох заалтанд ... хорих анги болон ялтны аюулгүй байдлыг хангах үндсэн үүргийг зааж өгсөн бөгөөд үйл ажиллагааны хүрээнд эрэн сурвалжлах ажиллагааг явуулах талаар зааж өгсөн.

Харин Хорих ангиас оргох гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлаж байхад хорих анги, цагдан хорих болон баривчлах ял эдлүүлэх байрны амьдралын болон үйлдвэрийн бүсээс харуул хамгаалалтын албан хаагчдын сонор сэрэмжгүй байдлыг ашиглах, албан хаагчийн итгэлийг олон түүн дээр түшиглэн харуул хамгаалалтын техник тоног төхөөрөмжийг эвдэж сүйтгэх, албан хаагчийн амь биед хүч хэрэглэн халдан довтлох зэрэг аргаар хорих ял эдэлхээс зайлсхийж байна.

Монгол Улс нийгэм, эдийн засгийн шинэ тогтолцоонд шилжиж буй сүүлийн жилүүдэд гэмт хэргийн тоон үзүүлэлт өсөхийн хэрээр гэмт үйлдлийн арга нарийсч илүү хор аюултайгаар өөрчлөгдөн, улам зохион байгуулалттай, нийгэм эдийн засаг, улс төр, бизнесийн салбар түүнчлэн эрүүгийн гэмт хэрэгтнүүдийг хамарсан шинэ өнгө аяс бүхий бүлэглэлүүд үүсч эрүүгийн

¹⁹ Эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл. 2011 он. 401 дэх тал.





гэмт хэргийн нөхцөл байдал хүндэрсээр байна.²⁰

Мөн хоригдогч, ялтны дундаас албан хаагчийн үүрэг гүйцэтгэлт, улмаар албаны үйл ажиллагаанд нөлөөлөхийг оролдох. өөртөө ашигтай шийдвэр гаргуулахыг эрмэлзэх, албан хаагчийг янз бүрийн аргаар эрхшээлдээ оруулахыг хичээх гэх мэт хорих анги, баривчлах, цагдан хорих байрны өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах зорилго бүхий үйлдлийг байнгын буюу тасралтгүй шинжтэйгээр үйлдсээр байна. Түүнчлэн хоригдогсод нь хорих анги, баривчлах, цагдан хорих байранд бусдын амь нас, эрүүл мэндийн эсрэг үйлдэж байгаа, мөн хорих ангиас харуул хамгаалалтын сул байдал эсхүл тухайн анги, албаны үйл ажиллагааны онцлог байдлыг ашиглан хамгаалалтын инженер-техникийн хэрэгслийг эвдэх, зориулалтын саад, төхөөрөмжийг давж туулах замаар ганцаар болон бүлэглэн оргох гэмт хэрэг үйлдсэн байна.

2002-2012 оны хугацаанд хорих, баривчлах, цагдан хорих байранд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил, дотоод нөхцөл байдлыг судалж үзвэл тэнд үйлдэгдэж буй гэмт хэргийн үйлдлийн арга хэлбэр нарийн, сайтар төлөвлөсөн, гарах үр дагаварыг урдаас тооцсон байхын зэрэгцээ хоригдогсодын сэтгэл зүйн өвөрмөц онцлог байдлаас шалтгаалан учруулж байгаа хор уршиг хүнд ноцтой шинжийг агуулж байгаа ба эдгээр гэмт хэргүүдийн дотроос хорих анги, баривчлах ял эдлүүлэх болон цагдан хорих байрнаас оргох гэмт хэрэг тодорхой хувийг эзэлж байна.

Сүүлийн 10 жилийн судалгаанаас харвал оргох гэмт хэрэг эхний жилүүдэд өндөр тоон үзүүлэлт харагдаж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд 5 дахин буурсан үзүүлэлт харагдаж байна. Энэ нь оргох гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрэн сурвалжлах ажилгаанд анхаарахгүй байж болно гэсэн ойлголт биш харин энэ талын ажиллагааг улам бүр нарийвчлан авч үзэн үйл ажиллагааг нийгмийн хөгжил бусад хүчин зүйлтэй холбогдуулан зохион байгуулалтын болоод урьдчилан сэргийлэх хүрээнд энэ талын үйл ажиллагааны удирдлага, урьдчилан сэргийлэх ажиллагааг улам бүр боловсронгуй болгох зайлшгүй шаардлага урган гарч ирсээр байна.

Эрэн сурвалжлах арга хэмжээнд хорих



²⁰ Б.Баясгалан., Магистрын ажил., 2010 он., 18 дахь тал.



байгууллагаас орголт гарсан анхны мэдээг хүлээж авмагц оргодол этгээдийн ул мөрийг илрүүлэх, бэхжүүлж авах эхний шатны арга хэмжээг авч хэргийн газраас оргосон, цаг хугацаа, оргодлын тоо, унаажсан болон зэвсэглэсэн эсэхийг тодорхойлон тухайн газар орны нөхцөл байдлаас шалтгаалан отолт, боолт, самналт хийх, олон нийтийн газруудыг шалгах, зам харилцааг хаах зэрэг ил арга хэмжээг шуурхай зохион байгуулан мөрийг нь олж илрүүлэн бэхжүүлэх арга хэмжээг авах нь зүйтэй. Ул мөрөөр нь мөрдөн хөөж орогнож, нуугдаж байж болзошгүй гэж үзсэн газрыг бүслэн хаах, самналт зохион байгуулах, отолт боолт хийх арга хэмжээг хугацаа алдалгүй авах зэрэг үндсэн үйл ажиллагааг удирдлага зохион байлтаар хангах шаардлагатай

Оргодлыг нэн түрүүнд баривчлан аюулгүй байдлыг хангахад энэ талын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж буй албан тушаалтны ур чадвар чухал ач холбогдолтой байдаг. Түүнчлэн эрэн сурвалжлах ажилтан /удирдах албан тушаалтан/ хорих байгууллагаас оргодол этгээд оргосон тохиолдолд эрэн сурвалжлах ажиллагааг дараахь үе шаттай явуулж болно. Үүнд:

1. Эрэн сурвалжлах ажилтан оргосон этгээдийн хань хамсаатан /гал хам/-ны яриа, өгүүлэлд хяналт тавин оргодлын явж, очих, байж болох чиглэл, орогнож болзошгүй газрын талаархи мэдээллийг олж авахад чиглэсэн арга хэмжээг зохионо.

Олдсон мэдээллийг үндэслэн тухайн оргодлын оргох болсон шалтгаан, нөхцлийг судалж түүний зорилгыг олж тогтоосноор эрэн сурвалжлах ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоон эрэн сурвалжлах хүн хүчийг хуваарилна.

2. Оргодол этгээдийн хувийн хэрэг, материал, авагдсан мэдээ, мэдээллийг нэгтгэн дүн шинжилгээ хийн таамаглал дэвшүүлнэ. Оргодол этгээдэд туслаж болох хүмүүс, ямар байдлаар тусламж дэмжлэг үзүүлж болох талаар дүрслэн тодорхойлно.

3. Оргодол этгээдийн талаархи эрэн сурвалжлах лавлагаа гаргана.

Эрэн сурвалжлах лавлагаанд доорхи мэдээллүүдийг багтаана.

Фото зураг, биеийн байцаалт, гадна төрх байдал, содон шинж тэмдэг, оргох үедээ өмсөж явсан хувцас, гэр бүл, садан төрөл, найз нөхөд, гэмт хэрэг хамтран үйлдэгсдийн оршин суух хаяг, албан газар, бусад орогнож болох газрууд гэх мэт зайлшгүй шаардлагатай

4. Эрэн сурвалжлах ажиллагаа явуулах төлөвлөгөөг нарийвчлан боловсруулна.

Төлөвлөгөөнд эрэн сурвалжлах ажиллагаанд оролцох хүн хүчний тооцоо, ямар унаагаар хэдий хугацаанд заагдсан газар хүрсэн байх, шатахуун хүнсэнд зарцуулах зардал, явах чиглэл, отолт хаалт, самналт хийх газар зэргийг тодорхой тусгаж өгнө.

5. Эрэн сурвалжлах бүлгүүдийг томилж дэвшүүлсэн таамаглалын дагуу орогнож нуугдаж болох газар, орон байрыг шалгана.

6. Орон нутгийн цагдаагийн байгууллагад мэдэгдэж олшруулсан эрэн сурвалжлах лавлагааг хүргүүлэх. Эрүүлжүүлэх байр болон албадан саатуулах газруудад оргодол этгээд байгаа эсэхийг нэн түрүүн шалгах шаардлагатай байдаг.

7. Оргодол этгээдийн талаар иргэд байгууллагад зарлах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдэгдэж тэдний тусалцааг авах, оргодлын талаархи мэдээллийг худалдан авах.



8. Тогтоол гүйцэтгэх газрын гүйцэтгэх алба /төв/-нд мэдэгдэж оргодол этгээдийн гэр бүл, садан төрөл, найз нөхөд, хам хэрэгтнүүдийн үйл хөдлөл, яриа өгүүлийг хяналтанд авах.

9. Оргодол этгээд орогнож байгаа газар, орон тогтоогдохгүй тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын гүйцэтгэх тагнуулын ажлын зааварт заасны дагуу эрэн сурвалжлах хэрэг нээж холбогдох арга хэмжээнүүдийг авах зэрэг үйл ажиллагааг удирдан зохион байгуулах нь зүйтэй.

10. Аймаг, орон нутгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулж байгаа хорих анги, баривчлах ял эдлүүлэх болон цагдан хорих байрнаас ялтан оргосон тохиолдолд хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны даргын тушаалаар батлагдсан эрэн сурвалжлах ажилтнуудын эрэн сурвалжлах бүлэг эрэн сурвалжлах ажлыг тухайн нутаг дэвсгэрт бүсчлэн шуурхай зохион байгуулна. Энэ төрлийн эрэн сурвалжлах ажиллагаанд эрэн сурвалжлах ажилтан тухайн газар орноо сайн мэддэг, иргэдийг таньдаг байх нь ихээхэн ач холбогдолтой. Орон нутгийн эрэн сурвалжлах ажиллагааг зохион байгуулахдаа тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хууль хяналтын байгууллагатай урьдчилан төлөвлөсний дагуу ажиллаж дэмжлэг авахын зэрэгцээ оршин суугаа иргэдийн мэдээ, мэдээллийг өргөнөөр ашиглах нь үр дүнтэй байдаг.

Орон нутгийн хэмжээний эрэн сурвалжлах ажиллагааг хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны удирдлага, гүйцэтгэх ажилтнууд зохион байгуулж оргодол этгээдийг баривчлах хүртэл хугацаанд үргэлжлүүлэн удирдаж байх нь зүйтэй.

Удирдлагын баг нь тухайн оргодол этгээдийн оршин сууж, ажиллаж амьдарч

байсан орон нутагт эрэн сурвалжлах ажиллагааг явуулахад нутгийн иргэд оргодол этгээдийг нуух, худал мэдээлэх, эрэн сурвалжлах ажиллагааг төөрөгдүүлэх гэх мэт хүндрэл бэрхшээлүүдээс урьдчилан сэргийлэхэд анхаарах шаардлагатай. Тиймээс энэ тохиолдолд мэдээлэл худалдан авах түүнчлэн тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ажилтнууд нь бусад байгууллагатай хамтран ажиллах чадварыг эзэмшсэн байвал зохино.

Улс орны хэмжээгээр зохион байгуулж буй эрэн сурвалжлах ажиллагаанд хууль хяналтын байгууллагуудыг оролцуулсаны үр дүнг харьяа байгууллагынхаа удирдлагад тогтмол танилцуулан холбогдох арга хэмжээг цаг алдахгүй шуурхай авч хэрэгжүүлж байх хэрэгтэй. Энэ нь дараагийн эрэн сурвалжлах ажиллагааг удирдан зохион байгуулахад чухал ач холбогдолтой.

Цаашид шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан албан хаагчид болон удирдлагын зүгээс харуул хамгаалалтыг оновчтой зөв зохион байгуулж ялтныг судлаж шинжлэх хяналт шалгалтын ажлыг эрчимтэй зохион байгуулж тодорхой арга хэмжээг авснаар оргох гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой бөгөөд дээрх дэвшүүлсэн санал дүгнэлтэнд тулгуурлан оргосон этгээдийг эрэн сурвалжлах ажиллагааны удирдлага зохион байгуулалтаар хангавал оргодлыг эрэн сурвалжлах ажиллагаанд ахиц гарна гэдэгт найдаж байна.